

## “ЗАЛУУ МАЛЧИН” ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг. Зорилго

Малчдад мал маллагааны арга ажиллагааны болон аж ахуй эрхлэх ур чадвар олгох, малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

### Хамтран зохион байгуулах газар:

- Аймгийн Засаг даргын Тамгын газар
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
- Хүнс, Хөдөө аж ахуйн газар
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
- Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага

### Хоёр. Хэрэгжүүлэх арга хэмжээ

- 2.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:
  - 2.1.1. Малчин өрхийг малжуулах;
  - 2.1.2. Аж ахуй эрхлэлтийн сургалт, шавь сургалт, туршлага солилцох бусад арга хэмжээг зохион байгуулах
- 2.2. Малчин өрхийг малжуулах арга хэмжээг зохион байгуулах
  - 2.2.1. Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хөдөлмөрийн чадвартай, 16-40 хүртэлх насны 2-оос доошгүй гишүүнтэй, богд шилжүүлснээр 250 хүртэл толгой малтай өрхийг хамруулна.
  - 2.2.2. Арга хэмжээнд хамрагдах малчин өрх нь богд шилжүүлснээр 150-200 хүртэл толгой малтай өрхөд 5.0 сая төгрөг, 200-250 хүртэлх толгой малтай өрхөд 4.0 сая төгрөгийн мал худалдан авах арга хэмжээг зохион байгуулна.
  - 2.2.3. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тухайн Сумын амьжиргаа дэмжих зөвлөлтэй хамтран худалдан авах ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
  - 2.2.4. Энэхүү хөтөлбөрт тухайн жилд хамрагдах сумд болон малчин өрхийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.
  - 2.2.5. Малжуулах дэмжлэгт хамрагдахаар сонгогдсон иргэнтэй аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар болон тухайн сумын Засаг дарга нар гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэж ажиллана.
  - 2.2.6. Гэрээнд эргэн төлөлтийг төлөх хэлбэр болон хуваарь, хөтөлбөрт заагдсан сургалтад оролцох талаар тусгасан байна.
  - 2.2.7. Ажлын хэсэг мал худалдан авч өгөх үйл ажиллагааг хуулийн дагуу нээлттэй, ил тод зохион байгуулна. Худалдан авч байгаа малын үнэ нь орон нутгийн зах зээлийн дундаж үнээс илүүгүй байна.
  - 2.2.8. Малчин өрхийг малжуулах үйл ажиллагааг тухайн оны 2 дугаар улиралд багтаан хэрэгжүүлнэ.

- 2.2.9. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан малчин өрх нь мал худалдан авч өгснөөс хойш 36 сарын дотор гэрээнд заасан хуваарийн дагуу 100 хувь эргүүлэн төлнө.
  - 2.2.10. Хөтөлбөрийн малжуулах арга хэмжээнд малчин өрх нь зөвхөн нэг удаа хамрагдана.
- 2.3. Аж ахуй эрхлэлтийн сургалт, шавь сургалт, туршлага солилцох уулзалт, бусад арга хэмжээг зохион байгуулах:
- 2.3.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдах малчин өрхөд аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалт явуулах, туршлага солилцох уулзалт зохион байгуулах, малын хашаа, хороо барих, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрэг дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.
  - 2.3.2. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулна.
  - 2.3.3. Аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар гэрээ байгуулан сургалтыг зохион байгуулж болно.
  - 2.3.4. Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн мал маллах арга ажиллагааг сайжруулах зорилгоор шавь сургалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна.
  - 2.3.5. Мал маллагааны талаар туршлагатай сайн малчдаас суралцах, туршлага солилцох, дэлгэрүүлэх зорилгоор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас уулзалт, хэлэлцүүлгийг жилд нэг удаа зохион байгуулна.

### **Гурав. Удирдлага, зохион байгуулалт**

- 3.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газар нь удирдлага, зохион байгуулалтаар, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь мэргэжил-арга зүйгээр тус тус хангаж, үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар зохион байгуулна.
- 3.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газар болон сумын Засаг даргын Тамгын газар, иргэдийн төлөөллийн байгууллага хяналт тавина.
- 3.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааны тайланг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хагас, бүтэн жилээр гаргаж, үр дүнгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс жилийн эцэст нэг удаа хийнэ.
- 3.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж ажиллана.
- 3.5. Аймгийн Засаг даргын зөвлөлд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга тухай бүр танилцуулж, шаардлагатай зөвлөмж, чиглэлийг хангаж ажиллахад анхаарна.
- 3.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээн дээр суурилсан байдлаар гаргаж албажуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

- 3.7. Дэд хөтөлбөрт тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, бичиг баримт хуурамчаар үйлдсэн болон бусад зөрчил, дутагдал гаргасан нь холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтаар тогтоогдвол олгосон санхүүжилтийг буцаан төлүүлэх арга хэмжээ авч, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

#### **Дөрөв. Шалгуур үзүүлэлт**

- 4.1. Хөтөлбөрийн үр дүнг дараах үзүүлэлтээр тооцно. Үүнд:
- 4.1.1. Малжуулах арга хэмжээнд 20 малчин өрхийн хөдөлмөрийн насны 40 гишүүд хамрагдана.
  - 4.1.2. Тухайн малчин өрх нь богд шилжүүлснээр 400-аас доошгүй мал /малын нэр төрлөөр/-тай болсон байна.
  - 4.1.2. Шавь сургалтад 5 малчин өрхийн 10 гишүүд хамрагдана.
  - 4.1.3. Аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалтад хөтөлбөрийн нийт малчин 20 өрхийн 40 гишүүд хамрагдана.
  - 4.1.4. Туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэгт 20 малчин өрх хамрагдана.
  - 4.1.5. Нийгмийн даатгалд малчин 20 өрхийг хамруулна.

#### **Тав. Үр дүн**

- 5.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн дагуу санхүүжилтийг үр дүнтэй зарцуулсан байна.
- 5.2. Малчин өрхийн анх хүлээж авсан малын тоог хөтөлбөрийн хугацаанд өссөн малын тоотой харьцуулж, өссөн үзүүлэлтээр /малын төрөл тус бүрээр/ үр дүнг тооцно.
- 5.3. Малчин өрх нь байнгын ажлын байртай болсноор өрхийн амьжиргааны түвшин нэмэгдсэн байна.